



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/147

Чойр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлаын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 04 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол сакура Буйлс цэцэглэх хавар” аялал жуулчлалын эвент зохион байгуулах хүрээнд “Боржигин идээний ёс уламжлал” арга хэмжээний зөвлөх болон бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйлчилгээний зардалд 6,875,000 (зургаан сая найман зуун далан таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Эвент арга хэмжээ зохион байгуулахтай холбогдон гарах зардал 6,875,000 (зургаан сая найман зуун далан таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ